



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А/133

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн 1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:


1. “Статистикийн мэдээллийг буруу, ташаа тайлбарлах, урвуулан ашиглах тохиолдолд залруулах, тайлбар хийх журам” -ыг хавсралтаар баталсугай.
2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Ч.Цэвэгдорж/-т үүрэг болгосугай.

ДАРГА



А.АРИУНЗАЯА

Үндэсний статистикийн хорооны даргын
2018 оны 12 сарын 05 өдрийн
А/133.. дугаар тушаалын хавсралт



**СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ БУРУУ, ТАШАА ТАЙЛБАРЛАХ,
УРВУУЛАН АШИГЛАХ ТОХИОЛДОЛД ЗАЛРУУЛАХ,
ТАЙЛБАР ХИЙХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь албан ёсны статистикийн мэдээллийг буруу, ташаа тайлбарлах, урвуулан ашиглах тохиолдолд залруулах, тайлбар хийх үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2 Үндэсний Статистикийн хорооноос албан ёсны залруулга болон тайлбар хийж, олон нийтэд мэдээлэх үйл ажиллагаанд Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 18, 21 дэх заалтууд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас баталсан “Албан ёсны статистикийн үндсэн зарчмууд”-ын 4 дэх, “Олон улсын статистикийн үйл ажиллагааны удирдлагын зарчмууд”-ын 7 дахь, “Монгол Улсын албан ёсны статистикийн чанарын удирдлагын стандарт хэм хэмжээ”-ний 1 дэх зарчмууд болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.
- 1.3 Шинжлэх ухааны үндэслэлтэй, нэгдсэн тайлбар бүхий хариу арга хэмжээг цаг алдалгүй, шуурхай авах зарчим баримтална.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

- 2.1 Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - 2.1.1 “урвуулан ашиглах” гэж албан ёсны статистикийн мэдээллийн дүн, утга агуулгыг хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх болон бусад зорилгоор өөрчлөн буруугаар ашиглахыг;
 - 2.1.2 “буруу тайлбарлах” гэж статистикийн мэдээлэл, түүний утга агуулгыг хэрэглэгч өөрийн хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн илтэд ташаа тайлбарлан, нийтэд мэдээлэхийг;
 - 2.1.3 “ташаа тайлбарлах” гэж статистикийн үзүүлэлтүүд, тэдгээрийн утга агуулгыг хэрэглэгч буруу ойлгох, андуурч тайлбарлахыг.

Гурав. Статистикийн мэдээллийг буруу, ташаа тайлбарлах, урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх

- 3.1 Статистикийн мэдээллийг буруу, ташаа тайлбарлах, урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлж дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 3.1.1 Статистикийн чанарын удирдлагын стандарт, чанарын тайлан, статистикийн мэдээллийг тархаах хуваарийг нийтэд ил тод, шуурхай мэдээлэх;
- 3.1.2 Хэрэглэгчдэд тархаах мэдээллийн хэл найруулгыг онцгой анхаарч, үг үсэг, найруулгын алдаагүй, энгийн богино өгүүлбэрээр ойлгомжтой илэрхийлэх;
- 3.1.3 Аргачлал, арга зүйн лавлагаа материал, дэлгэрэнгүй тоо мэдээллийг авах холбоос, холбоо барих ажилтны талаарх мэдээллийг ил тод байршуулж, өөрчлөлтийг тухай бүр тусгах;
- 3.1.4 Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр хэрэглэгчидтэй харьцах харилцаа, арга барил, интернэт орчинд харилцах ёс зүйгээ тодорхойлж, хэрэгжүүлэх;
- 3.1.5 Статистикийн үйл ажиллагаа, тоо мэдээллийн талаарх ойлголт мэдлэг олгох ажлыг өргөжүүлэх;
- 3.1.6 Статистикийн мэдээллийг урвуулан ашиглах, буруу, ташаа тайлбарлах тохиолдол үүсч байгаа шалтгаан, нөхцөлийг баримтжуулж, түүнд дүн шинжилгээ хийж, үр дагаврыг арилгах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж байх.

Дөрөв. Статистикийн мэдээллийг буруу, ташаа тайлбарлах, урвуулан ашиглах хэв шинж

- 4.1 Хэв шинжээр нь:
 - 4.1.1 Шинж чанараар нь:
 - Урвуулан ашиглах;
 - Ташаа тайлбарлах;
 - Буруу тайлбарлах;
 - 4.1.2 Цар хүрээгээр нь:
 - Хязгаарлагдмал хүрээнд нийтэд тархсан буюу зөвхөн өдөр тутмын хэвлэлд нийтлэгдсэн;
 - Өргөн хүрээнд нийтэд тархсан буюу өдөр тутмын хэвлэл, цахим хуудсуудад нийтлэгдсэн;
 - Нийтийг хамарч, олны анхаарлыг татсан буюу хэвлэл мэдээллийн бүх төрлийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр зэрэг тархсан гэж ангилна.

Тав. Статистикийн мэдээллийг буруу, ташаа тайлбарлах, урвуулан ашигласан тохиолдлыг илрүүлэх, тогтоох, ангилах

- 5.1 Статистикийн мэдээллийг буруу, ташаа тайлбарлах, урвуулан ашиглах тохиолдлыг илрүүлэх ажлыг Тамгын газар нэгтгэн зохион байгуулна.
- 5.2 Статистикийн мэдээллийг буруу, ташаа тайлбарлах, урвуулан ашигласан тохиолдлыг тогтоох, ангилах үйл ажиллагааг Тамгын газар холбогдох ажлын хэсэг, нэгжтэй хамтран шийдвэрлэнэ.

- 5.3 Статистикийн мэдээллийг буруу, ташаа тайлбарлах, урвуулан ашиглах тохиолдлыг илрүүлэхэд дараах аргыг ашиглана:
- 5.3.1 Хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээнд мониторинг тогтмол хийх;
- 5.3.2 Хэвлэл мэдээллийн ажилтнуудын лавлагаа, тодруулга болон статистикийн мэдээллийг урвуулан ашигласан эсхүл буруу, ташаа тайлбарлаж байгаа талаарх бусад мэдээлэл ашиглах;
- 5.4 ҮСХ-ны болон аймаг, нийслэл, дүүрэг дэх статистикийн салбар нэгжийн ажилтан, статистикийн улсын байцаагч нь статистикийн мэдээллийг буруу, ташаа тайлбарлах, урвуулан ашигласан тохиолдлыг илрүүлсэн тухай бүр ҮСХ-ны мэдээлэл тархаалт, олон нийттэй харилцах асуудал эрхэлсэн нэгжид шуурхай мэдэгдэнэ.

Зургаа. Статистикийн мэдээллийг буруу, ташаа тайлбарлах, урвуулан ашигласан тохиолдолд авах хариу арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх

- 6.1 Статистикийн мэдээллийг буруу, ташаа тайлбарлах, урвуулан ашиглах тухайн тохиолдлын шинж чанар, хамарсан цар хүрээнээс шалтгаалан дараах арга хэмжээг авна:
- 6.1.1 Сэтгүүлчтэй холбогдох – хэвлэл мэдээллийн хэрэгсэлд статистикийн мэдээллийг буруу тайлбарласан нь хязгаарлагдмал хүрээнд нийтэд тархсан тохиолдолд мэдээлэл нийтэлсэн сэтгүүлчтэй утсаар холбогдох эсхүл цахим шуудан илгээж, залруулах арга хэмжээг авна.
- 6.1.2 Хэвлэл мэдээллийн хэрэгслийн редакцад албан захидал илгээх - статистикийн мэдээллийг буруу, ташаа тайлбарласан нь хязгаарлагдмал хүрээнд нийтэд тархсан тохиолдолд энэ арга хэмжээг авна.
- 6.1.3 Байгууллага, хувь хүнтэй холбогдох –Байгууллагын цахим хуудас болон хувь хүний нийтэлсэн мэдээлэлд статистикийн мэдээллийг буруу, ташаа тайлбарласан тохиолдолд байгууллагын дарга, хувь хүнд мэдэгдэж залруулах арга хэмжээ авна.
- 6.1.4 Хэвлэл мэдээллийн байгууллагын дарга/захирал/эрхлэгчид хандсан албан захидал илгээх - статистикийн мэдээллийг ташаа мэдээлсэн эсхүл буруу, ташаа тайлбарласан нь ноцтой алдаанд тооцогдож, хязгаарлагдмал хүрээнд нийтэд тархсан тохиолдолд энэ арга хэмжээг авна.
- 6.1.5 Хэвлэлийн мэдээлэл нийтлэх - статистикийн мэдээллийг ташаа мэдээлсэн эсхүл буруу, ташаа тайлбарласан нь ноцтой алдаанд тооцогдож, өргөн хүрээнд нийтэд тархсан тохиолдолд энэ арга хэмжээг авна.
- 6.1.6 Харьяа дээд шатны байгууллагад мэдэгдэж залруулга хийлгэх – Төрийн болон төрийн бус байгууллагын дарга, аж ахуйн нэгжийн удирдах ажилтны нийтэд хандаж хэлсэн үг, тавьсан илтгэл, танилцуулгад статистикийн мэдээллийн үр дүнг буруу, ташаа тайлбарласан нь өргөн хүрээнд нийтэд тархсан тохиолдолд энэхүү арга хэмжээг авна.

- 6.1.7 Хэвлэлийн бага хурал болон олон нийтэд хандсан хариу мэдэгдэл хийх - статистикийн мэдээллийг ташаа мэдээлсэн эсхүл буруу, ташаа тайлбарласан нь нийтийг хамарч, олны анхаарал татсан тохиолдолд энэ арга хэмжээг авна.
- 6.2 Энэхүү журмын 6.1.1-6.1.3-д заасан арга хэмжээг ҮСХ-ны мэдээлэл тархаалт, олон нийттэй харилцах асуудал эрхэлсэн нэгж, холбогдох газар, нэгжийн удирдлагатай хамтран; 6.1.4-6.1.5-т заасан арга хэмжээг Тамгын газар; 6.1.6-6.1.7-д заасан арга хэмжээг ҮСХ-ны удирдлагын түвшинд хэлэлцэж, хэрэгжүүлнэ.
- 6.3 Статистикийн мэдээллийг буруу, ташаа тайлбарлах, урвуулан ашиглах тохиолдлуудыг баримтжуулж, үүсч байгаа шалтгааныг тодорхойлж, дүн шинжилгээ хийж, үр дагаврыг арилгах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх ажлыг Тамгын газар, холбогдох нэгжтэй хамтран зохион байгуулна.
- 6.4 Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийх асуудлыг ҮСХ-ны хяналт шинжилгээ, үнэлгээний асуудал эрхэлсэн нэгж хариуцан зохион байгуулна.
- 6.5 Статистикийн мэдээллийг буруу, ташаа тайлбарлах, урвуулан ашигласнаас гарсан үр дагавраас хамааран холбогдох хууль, эрх зүйн актад заасны дагуу тухайн этгээдэд хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---